

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор */ард/* хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

**Хуульд заасан шаардлага:** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.4.Байнгын хорооноос санал болгох нэр дэвшигч хувийн хэвшлийг төлөөлсөн байж болно.

11.5.Хорооны гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

11.5.1.төрийн улс төрийн албан хаагч;
11.5.2.улс төрийн намын удирдах албан тушаалтан;
11.5.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

11.5.4.санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдэд ажиллаж байгаа этгээд;

11.5.5.санхүүгийн үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч.

11.6.Хорооны дарга, гишүүн нь эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, Монгол Улсын иргэн байна.

## НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| 1.1 | **Эцэг/эхийн нэр:** Бөхбат<br>**Ургийн овог:** Боржигон тугч<br>**Нэр:** Бат-Эрдэнэ<br>**Хүйс:** Эр<br>**Төрсөн он:** 1985<br>**Төрсөн газар:** Хэнтий аймаг, Гурванбаян<br>**Иргэний харьяалал:** Монгол улс<br>**Одоо оршин суугаа аймаг /*нийслэл, сум*/ дүүрэг:** ХУД, 15-р хороо<br>*/мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/* |
| 1.2 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал**<br>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн |
| 1.3 | **Иргэний харьяалал**<br>Монгол Улсын иргэн мөн эсэх<br>*/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/*<br><br>ТИЙМ |
| 1.4 | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дараалаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.<br>*/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/*<br>- МУИС-Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлага/санхүү/-ын магистр, 2024 он<br>- ШУТИС-Барилгын инженер, архитектурын сургууль, Барилгын инженерийн бакалавр, 2010 он<br>- Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Бизнесийн удирдлагын бакалавар, 2007он |
| 1.5 | **Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг**<br>. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . |
| 1.6 | **Эрүүл мэнд**<br>Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана.<br>- СЭМҮТ-ийн тодорхойлолт хавсаргав. |
| 1.7 | **Эрхэлсэн ажил**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, үнэт цаас, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана.<br><br>Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар жагсаах бөгөөд ажил олгогч */эсхүл, удирдах албан тушаалтан/*-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.<br>- Хөвсгөл мөнгөн од ХХК-д Санхүүгийн зөвлөх /2025.01-одоог хүртэл/ |

| | |
|---|---|
| | - Кибер жаал ХХК-д Санхүүгийн зөвлөх /2024.10-одоог хүртэл/<br>- Барилга, хот байгуулалтын яаманд Зөвлөх /2023.01-2024.07сар/<br>- "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д Борлуулалт /ХҮА/ хариуцсан дэд захирал /2018.04-2022.06/<br>- "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-д Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга /2016.11-2018.03/<br>- "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн /2016.11-2017.05/<br>- ЗГХАгентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Худалдан авах үйл ажиллагааны хэлтэст Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /2016.08-2016.11/<br>- ЗГХАгентлаг Худалдан авах ажиллагааны газрын Санхүү, худалдан авалтын хэлтэст Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /2012.12-2016.07/<br>- ЗГХАгентлаг Мэргэжлийн боловсрол сургалтын газарын Санхүүгийн хэлтэст Санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн /2010.04-2011.04/<br>- "Хера-Экуйпмент" ХХК-д Борлуулалтын мэргэжилтэн /2008.03-04/<br>- Хөрөнгө оруулалтын "Юу Ти И Эй" ХХК-ийн санхүүгийн хэлтэст Судалгааны мэргэжилтэн /2008.05-07/<br>- "АПУ" ХК-д Санхүүгийн мэргэжилтэн /2008.02-04/ |
| 1.8 | **Ашиг сонирхлын зөрчил**<br>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих.<br>*/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичих/*<br>- Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг эсэх - **Тийм** / 2010 онд байгуулагдсан, Худалдаа болон хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг "Өсөх прогресс" ХХК-ийн 51,2 хувийн хувьцаатай/<br>- Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх - **Үгүй**<br>- Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэх -**Үгүй** |
| 1.9 | **Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал**<br>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих.<br>*/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичих/.*<br>- Үгүй |
| 1.10 | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих.<br>*/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичих/* |

| | |
|---|---|
| | - Үгүй |
| 1.11 | **Мэргэжлийн ёс зүйн талаар**<br>Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх.<br>*/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалдаар бичих/.*<br><br>- Үгүй. |
| 1.12 | **Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол**<br><br>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br><br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br><br>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.<br><br>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.<br><br>*/**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/*<br><br>- Байхгүй |

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| 2.1 | Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ.<br><br>1. Банкнаас бусад санхүүгийн салбарт өнөөдрийг хүртэл банкны үзүүлсэн нөлөө чухал байсан. Харин цаашид банкны оролцоог бууруулж мэргэжлийн байгууллагуудад хөгжих боломжийг олгох чиглэлд анхаарч ажиллана. Энэ нь олон талын үр ашигтай.<br><br>2. Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр хийх ажил.<br><br>Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ын зээлийн хүүгийн түвшинг |

бууруулах замаар хэрэглэгчидэд ээлтэй санхүүгийн орчин бүрдүүлнэ. Зээлийн хүүг бууруулах бүрэн боломжтой. Өнөөдөрийн тогтсон зээлийн хүүгийн түвшин нь иргэдийг өндөр зээлийн хүүгийн дарамтад оруулж байна. Энэ нь иргэдийн итгэлийг сулруулж цаашлаад ББСБ-ын тогтвортой байдалд эрсдэл учруулах сөрөг нөлөөтэй.

ББСБ-ын ашигт ажиллагаанд нарийн судалгаа явуулж Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээний түвшинд зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана. 2024 оны 3-р улиралын тоо мэдээгээр энэ салбарын нийт хөрөнгө 6.4 ихнаяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь 2023 оны мөн үеэс 50 хувь өссөн үзүүлэлт.

Бусад. Үүнд: Иргэдийн хэрэглээний зээл их авдаг асуудалыг бууруулах чиглэлд соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах. Зээлийн гэрээний нөхцөлөө бүрэн судалж ойлголгүй зээл авч л байвал болно гэсэн буруу хэвшлийг өөрчлөх. Зээлдэгчийн зээлийн түүх, орлогын түвшин, барьцаа хөрөнгө, зээлийн эрсдэл зэрэг дээр үндэслэж зээлийн хүүг олон түвшинд тогтоодог тогтолцоог бий болгох. Мөн ББСБ-ууд хувьцаат компани болох, бонд босгох нь цаашид түгээмэл болох хандлагатай байгаа тул үүнд онцгой анхаарч ажиллах болно. Энэ салбар нь өөрөө төрийн зохицуулалттай салбар тул ББСБ-ын тоо, зах зээлийн тэлэлт, зээлийн хүү зэрэг нь цаашид ямар түвшинд байхад тохиромжтойг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлуулж дунд болон урт хугацаанд хэрэгжүүлж ажиллахад анхаарна.

3. Даатгалын салбарт

Монголчуудын даатгалд хандах хандлагат онцгой өөрчлөлт авчрах тал дээр анхаарч ажиллана. Учир нь даатгалын салбар зөв хөгжиж байж санхүүгийн салбар өсөж өндийх хөшүүрэг болно. Яагаад монголчууд даатгалд дургүй, түүнийг ойлгохгүй байна вэ. Энэ их энгийн жишээ нь монголд үйл ажиллагаа явуулж байгаа нэг л даатгалын компани жилд 8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаа хэрнээ нөхөн төлбөр дээр хойрго ханддаг гэсэн ойлголт иргэдийн дунд түгээмэл байдаг нь энэ салбарын хөгжлийг хойш татаж байна.

Харин түүний оронд иргэний нэг жилд өгсөн даатгалын хураамж тухайн иргэний төлөө тогтмол /сүүлийн нэг дусал цусаа дуустал гэдэг шиг/ ажиллаж байх шинэ тогтолцоог салбарт нэвтрүүлэх замаар өөрчлөлт хийх хэрэгтэй. Энэхүү өөрчлөлтийг УИХ-тай хамтарч хийж хэрэгжүүлнэ. Энэ нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа даатгалын нөөц санг зөв удирдах мөн даатгалын хураамжинд олон төрлийн сонголт бий болгоход чиглэсэн бодлогын арга хэмжээ юм. Ингэснээр даатгуулагчид өгөөжтэй даатгалын тогтолцоог бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Олны анхаарлын төвд байдаг жолоочын албан журмын даатгалын тогтолцоог

| | |
|---|---|
| | иргэдэд таатай нөхцөл бүрдүүлэх замаар шаардлагатай өөрчлөлтийг хийх. Даатгалын хугацаанд осол, эрсдэлгүй байсан иргэдийн дараагийн жилийн хураамжинд олон төрлийн урамшуулал олгох байдлаар ажилладаг болгох.<br><br>4. Хөрөнгийн зах зээлийн хүрээнд хийх ажил.<br><br>Монголын хөрөнгийн зах зээл өөрийн боломжит түвшинд хөгжиж байна. Илрэл нь ТОП-20, MSE-A, MSE-B индексийн өсөлтөөс харж болно. Явж ирсэн энэ хөгжлийн хурд дээр тулгуур болох бодлогын болоод зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зөв. Ингэж байж банк давамгайлсан санхүүгийн зах зээлийн тогцолцоог өөрчлөх боломж бүрдэнэ. Үүний тулд хөрөнгийн зах зээлд оролцогч, харилцагчидын тоог нэмэгдүүлэх замаар энэ зах зээлийг идвэхжүүлэх шаардлагатай юм. Иймд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. Мөн даатгалын нөөц сан болон даатгалын компаниудын цэвэр ашгийн тодорхой хувийг энэ зах зээлд оруулалах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд шаардлагатай зохицуулалтыг хийж ажиллана. Бодлогын түвшинд мөн УИХ-тай хамтран ажиллана.<br>Нөгөө талаас хөрөнгийн зах зээлд оролцогчидын тоог нэмэгдүүлэхийн тулд жижиг хувьцаа эзэмшигчидийн эрх ашгийг хамгаалах нь тулгамдсан асуудал. Иймд хууль дүрмийн хүрээнд тэдэнд давуу байдал олгох боломжийг эрэлхийлж ажиллана. |

**Хавсралт:**

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

**1**.Төрийн албан хаагчийн анкет; **Хавсаргав**
**2**.Эрх бүхий байгууллагаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр; *I..............I*
**3**.Иргэний үнэмлэхийн хуулбар; **Хавсаргав**
**4**.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг; **Хавсаргав**
**5**.Боловсролын зэргийн дипломын хуулбар; **Хавсаргав**
**6**.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг; *I.................I*
**7**.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт заасан чиглэлээр мэргэшсэн, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт **Хавсаргав; Үүнд:**

*1. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавар зэрэгтэй төгссөн дипломын хуулбар*
*2. МУИС-Бизнесийн сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн дипломын хуулбар*
*3. Компаний засаглалын гэрчилгээний хуулбар*
*4. Хөрөнгийн зах зээл дээр Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн үнэмлэхний хуулбар*

*5. Койка-ийн санхүү, худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдаж байсан сертфикатын хуулбар*

*6. Азийн хөгжлийн банкны сургалтанд хамрагдаж байсан сертфикатын хуулбар*

*7. Санхүү чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан байгууллагууд.*

*-Хөвсгөл мөнгөн од ХХК-д Санхүүгийн зөвлөх /2025.01-одоог хүртэл/*

*-Кибер жаал ХХК-д Санхүүгийн зөвлөх /2024.10-одоог хүртэл/ дээш жил*

*-"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д Борлуулалт /ХҮА/ хариуцсан дэд захирал /2018.04-2022.06/*

*-ЗГХАгентлаг Худалдан авах ажиллагааны газрын Санхүү, худалдан авалтын хэлтэст Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /2012.12-2016.07/*

*-ЗГХАгентлаг Мэргэжлийн боловсрол сургалтын газарын Санхүүгийн хэлтэст Санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн /2010.04-2011.04/*

*-"Хера-Экуйпмент" ХХК-д Борлуулалтын мэргэжилтэн /2008.03-04/*

*-Хөрөнгө оруулалтын "Юу Ти И Эй" ХХК-ийн санхүүгийн хэлтэст Судалгааны мэргэжилтэн /2008.05-07/*

*-"АПУ" ХК-д Санхүүгийн мэргэжилтэн /2008.02-04/*

*8. Сангийн яамны жуух бичиг*

*9. Худалдан авах үйл ажиллагааны А3 сертфикатын хуулбар*

*10. ММҮИстетудын удирдах зөвлөлд ажиллаж байсан тухай тодорхойлолт*

**8**.Энэхүү загварт заасан баримт бичиг;

**9**.Холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Бөхбат

Өөрийн нэр: Бат-Эрдэнэ

Гарын үсэг: Б. Бат-Эрдэнэ

Он, сар, өдөр: 2025.04.18